



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/47

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Ховд, Мянгад сум) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүдэд: Д.Дөмөгтүшиг - Аймгийн Засаг даргын Тамгын Газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн

Н.Жавзанханд - Төрийн бус байгууллагын төлөөлөл


Г.Галмандах - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Х.Дэмид - Худалдан авах ажиллагааны албаны
мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Н.Ганзориг)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Х.Дэмид)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

8400 03 4563 D/Tush-A/47-Bo